



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/01-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Алтантуяа Утас: 703333019 Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Албан шаардлага	17
4.2 Зөвлөмж	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БХЯ	Батлан хамгаалах яам
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХШҮДАХ	Хяналт- шинжилгээ үнэлгээ,дотоод аудитын хэлтэс



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ЗДТГ-ЫН
ДАРГА Ц.БАДРАХ ТАНАА

2022.02.25 № 142
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *J. Amidi* Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	43,007,838.00	45,190,748.00
35	БАРАА МАТЕРИАЛ	43,007,838.00	45,190,748.00
35400	Хангамжийн материал	43,007,838.00	45,190,748.00
35410	Бичиг хэргийн материал	7,981,200.00	6,240,750.00
35420	Аж ахуйн материал	15,140,927.00	14,517,858.00
35430	Сэлбэг хэрэгсэл	5,780,200.00	6,457,200.00
35440	Түлш, шатах тослох материал	193,011.00	62,440.00
35450	Барилгын засварын материал	45,000.00	45,000.00
35470	Бусад хангамжийн материал	13,867,500.00	17,867,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,289,065,819.79	3,646,838,730.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,289,065,819.79	3,646,838,730.99
39200	Биет хөрөнгө	3,211,880,319.79	3,163,903,730.99
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,988,281,068.08	2,988,281,068.08
39202	Хуримтлагдсан элэгдэл	-104,606,113.44	-156,766,455.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	455,830,000.00	455,830,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-360,030,277.84	-403,589,444.42
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	327,433,456.65	421,978,756.65
39206	Хуримтлагдсан элэгдэл	-178,608,292.02	-230,448,683.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	195,801,330.42	206,891,330.42
39208	Хуримтлагдсан элэгдэл	-112,220,852.06	-139,978,535.28
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	0.00	23,900,000.00
39212	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-2,194,305.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	53,500,000.00	53,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-53,500,000.00	-53,500,000.00
39300	Биет бус хөрөнгө	77,185,500.00	482,935,000.00
39301	Програм хангамж	2,980,000.00	2,980,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,514,500.00	-2,755,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	106,720,000.00	512,710,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-30,000,000.00	-30,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,332,073,657.79	3,692,029,478.99
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,332,073,657.79	3,692,029,478.99
51	Засгийн газрын хувь оролцоо	3,332,073,657.79	3,692,029,478.99
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,223,981,214.28	2,223,981,214.28
51200	Хуримтлагдсан үр дүн	-1,182,725,250.71	-822,769,429.51
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,077,980,726.47	-1,182,725,250.71
51220	Тайлант үеийн үр дүн	-104,744,524.24	359,955,821.20
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,290,817,694.22	2,290,817,694.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,332,073,657.79	3,692,029,478.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,360,353,438.00	4,626,205,152.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	107,316,770.00	522,231,933.21
120	Нийтлэг татварын бус орлого	107,316,770.00	519,546,633.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,439,170.00	426,805,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,439,170.00	20,815,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	405,990,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	79,877,600.00	88,740,733.21
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0.00	4,000,000.00
122	Тусламжийн орлого	0.00	2,685,300.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	2,685,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,253,036,668.00	4,103,973,219.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,372,415,468.00	891,712,619.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,011,520.00	414,082,847.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,270,403,948.00	477,629,772.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,880,621,200.00	3,212,260,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,880,621,200.00	3,212,260,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,453,917,962.24	4,266,249,331.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,453,917,962.24	4,266,249,331.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,290,646,718.60	3,542,924,269.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,618,821.00	945,497,138.69
210101	Үндсэн цалин	572,138,675.00	533,564,910.17
210102	Нэмэгдэл	217,270,154.00	346,532,555.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	61,137,900.00	52,893,871.52
210105	Гэрээт ажлын хөлс	72,092.00	12,505,802.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,732,007.36	114,544,016.76
210201	Тэтгэврийн даатгал	65,884,269.66	84,927,012.50
210202	Тэтгэмжийн даатгал	7,749,326.99	8,483,487.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,199,461.59	5,355,379.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,486,583.11	1,383,266.84
210205	Эрүүл мэндийн даатгал	16,412,366.01	14,394,870.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,319,431.00	233,384,092.00
210301	Гэрэл, цахилгаан	9,451,237.00	9,899,348.00
210302	Түлш, халаалт	219,893,520.00	219,893,520.00
210303	Цэвэр, бохир ус	2,974,674.00	3,591,224.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,708,089.75	108,971,393.00
210401	Бичиг хэрэг	26,370,883.75	30,807,580.00
210402	Тээвэр, шатахуун	69,931,789.00	35,397,171.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,701,637.00	15,862,053.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	3,005,200.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	1,833,650.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	24,623,780.00	22,065,739.00
2105	Нормативт зардал	27,548,400.00	1,440,000.00
210502	Хоол, хүнс	24,188,400.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,360,000.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,398,845.00	61,360,495.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	693,000.00	1,502,100.00
210604	Урсгал засвар	42,705,845.00	59,858,395.00
2107	Томилолт, зочны зардал	37,065,800.00	20,482,000.00
210702	Дотоод албан томилолт	33,121,500.00	20,482,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,944,300.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	198,783,657.00	274,561,745.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,296,297.00	261,796,149.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,455,490.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	502,608.00	387,066.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	179,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,045,000.00	7,585,000.00
210807	Газрын төлбөр	360,752.00	2,717,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,661,471,667.49	1,782,683,389.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,424,970,811.00	1,602,084,267.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,329,845.00	6,576,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	206,171,011.49	174,023,122.01
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,271,243.64	723,325,061.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,967,903.00	53,053,480.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	120,703.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	7,570,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,949,300.00	1,783,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,897,900.00	43,699,480.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	135,303,340.64	670,271,581.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,392,356.92	487,566,529.83
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	99,910,983.72	182,705,051.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-93,564,524.24	359,955,821.20
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	11,180,000.00	0.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	11,180,000.00	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-104,744,524.24	359,955,821.20

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,293,278,186.40	-1,080,441,218.65	3,436,818,182.03
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,460,492.18	2,460,492.18
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,223,981,214.28	2,293,278,186.40	-1,077,980,726.47	3,439,278,674.21
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-2,460,492.18	0.00	-2,460,492.18
5	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-104,744,524.24	-104,744,524.24
6	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-1,182,725,250.71	3,332,073,657.79
7	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-1,182,725,250.71	3,332,073,657.79
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-1,182,725,250.71	3,332,073,657.79
10	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	359,955,821.20	359,955,821.20
11	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,223,981,214.28	2,290,817,694.22	-822,769,429.51	3,692,029,478.99

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,280,475,838.00	4,124,789,119.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	27,439,170.00	20,815,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	27,439,170.00	20,815,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	27,439,170.00	20,815,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	27,439,170.00	20,815,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,253,036,668.00	4,103,973,219.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,372,415,468.00	891,712,619.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	22,011,520.00	414,082,847.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	80,000,000.00	0.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,270,403,948.00	477,629,772.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,880,621,200.00	3,212,260,600.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,880,621,200.00	3,212,260,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,247,001,338.00	4,090,409,119.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,247,001,338.00	4,090,409,119.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,083,548,697.36	3,367,084,057.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	850,698,134.00	945,497,138.69
210101	Үндсэн цалин	427,045,543.00	569,368,474.71
210102	Нэмэгдэл	276,817,600.00	311,573,707.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,202,431.00	48,399,797.00
210105	Гэрээт ажлын хөлс	121,632,560.00	16,155,159.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	97,773,397.36	114,544,016.76
210201	Тэтгэврийн даатгал	79,028,998.34	78,556,096.77
210202	Тэтгэмжийн даатгал	8,318,500.00	8,760,278.02
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,839,899.02	6,981,341.17
210204	Ажилгүйдлийн даатгал	1,386,000.00	1,692,144.16
210205	Эрүүл мэндийн даатгал	3,200,000.00	18,554,156.64
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	232,319,431.00	233,384,092.00
210301	Гэрэл, цахилгаан	9,451,237.00	9,899,348.00
210302	Түлш, халаалт	219,893,520.00	219,893,520.00
210303	Цэвэр, бохир ус	2,974,674.00	3,591,224.00
2104	Хангамж, бараа материалын зардал	118,743,400.00	98,619,883.00
210401	Бичиг хэрэг	16,378,200.00	22,381,800.00
210402	Тээвэр, шатахуун	70,124,800.00	35,266,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,160,400.00	15,428,093.00
210404	Ном, хэвлэл	1,000,000.00	4,334,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,080,000.00	8,600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,000,000.00	12,609,190.00
2105	Нормативт зардал	27,540,000.00	1,440,000.00
210502	Хоол, хүнс	24,180,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,360,000.00	1,440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,954,100.00	64,696,125.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,531,000.00	5,720,000.00
210604	Урсгал засвар	25,423,100.00	58,976,125.00
2107	Томилолт, зочны зардал	37,065,800.00	20,482,000.00
210702	Дотоод албан томилолт	33,121,500.00	20,482,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,944,300.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	199,850,300.00	273,956,745.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	195,391,400.00	261,853,123.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,455,490.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	400,000.00	330,092.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	230,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,045,000.00	6,980,000.00
210807	Газрын төлбөр	383,900.00	2,717,040.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,484,604,135.00	1,614,464,057.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,454,231,290.00	1,607,888,057.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	30,372,845.00	6,576,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	163,452,640.64	723,325,061.55
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,149,300.00	53,053,480.00

Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.00	7,570,200.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,949,300.00	1,783,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,200,000.00	43,699,480.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	135,303,340.64	670,271,581.55
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	35,392,356.92	487,566,529.83
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	99,910,983.72	182,705,051.72
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	33,474,500.00	34,380,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	33,474,500.00	34,380,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,474,500.00	34,380,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,474,500.00	34,380,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	33,474,500.00	34,380,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-33,474,500.00	-34,380,000.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,224,260,600.00	2,745,509,970.17	478,750,629.83	85.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,224,260,600.00	2,745,509,970.17	478,750,629.83	85.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,167,997,200.00	2,692,456,490.17	475,540,709.83	85.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	934,288,800.00	929,341,979.17	4,946,820.83	99.5
210101	Үндсэн цалин	585,841,200.00	569,368,474.71	16,472,725.29	97.2
210102	Нэмэгдэл	290,235,600.00	311,573,707.46	-21,338,107.46	107.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	58,212,000.00	48,399,797.00	9,812,203.00	83.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	112,444,000.00	112,443,995.00	5.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	76,636,000.00	76,456,075.01	179,924.99	99.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,952,000.00	8,760,278.02	191,721.98	97.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,161,600.00	6,981,341.17	180,258.83	97.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,790,400.00	1,692,144.16	98,255.84	94.5
210205	Эрүүл мэндийн даатгал	17,904,000.00	18,554,156.64	-650,156.64	103.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,470,500.00	233,384,092.00	2,086,408.00	99.1
210301	Гэрэл, цахилгаан	10,094,000.00	9,899,348.00	194,652.00	98.1
210302	Түлш, халаалт	219,894,900.00	219,893,520.00	1,380.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	5,481,600.00	3,591,224.00	1,890,376.00	65.5
2104	Хангамж, бараа материалын зардал	103,533,200.00	98,619,883.00	4,913,317.00	95.3
210401	Бичиг хэрэг	22,381,800.00	22,381,800.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	35,266,600.00	35,266,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,087,800.00	15,428,093.00	4,659,707.00	76.8
210404	Ном, хэвлэл	4,600,000.00	4,334,200.00	265,800.00	94.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,600,000.00	8,600,000.00	0.00	100.0

Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,597,000.00	12,609,190.00	-12,190.00	100.1
2105	Нормативт зардал	4,400,000.00	1,440,000.00	2,960,000.00	32.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,400,000.00	1,440,000.00	2,960,000.00	32.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	115,780,200.00	88,976,125.00	26,804,075.00	76.8
210601	Багаж, техник, хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00	0.00	100.0
210602	Тавилга	26,780,200.00	0.00	26,780,200.00	-
210604	Урсгал засвар	59,000,000.00	58,976,125.00	23,875.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	29,935,300.00	20,482,000.00	9,453,300.00	68.4
210702	Дотоод албан томилолт	29,935,300.00	20,482,000.00	9,453,300.00	68.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	187,528,600.00	184,157,091.00	3,371,509.00	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	174,988,700.00	172,053,469.00	2,935,231.00	98.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00	500,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,455,490.00	44,510.00	97.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	333,300.00	330,092.00	3,208.00	99.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	191,700.00	121,000.00	70,700.00	63.1
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,980,000.00	6,980,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	3,034,900.00	2,717,040.00	317,860.00	89.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,444,616,600.00	1,023,611,325.00	421,005,275.00	70.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,442,016,600.00	1,023,451,325.00	418,565,275.00	71.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,600,000.00	160,000.00	2,440,000.00	6.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56,263,400.00	53,053,480.00	3,209,920.00	94.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,263,400.00	53,053,480.00	3,209,920.00	94.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	7,570,200.00	7,570,200.00	0.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,800,000.00	1,783,800.00	16,200.00	99.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,893,200.00	43,699,480.00	3,193,720.00	93.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,224,260,600.00	2,745,509,970.17	478,750,629.83	85.2
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,150,401,800.00	2,724,694,070.17	-574,292,270.17	126.7
320001	Орон нутгийн төсвөөс	2,150,401,800.00	2,724,694,070.17	-574,292,270.17	126.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,073,858,800.00	20,815,900.00	1,053,042,900.00	1.9
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,000,000.00	20,815,900.00	-8,815,900.00	173.5
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	127.00	143.00	-16.00	112.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.0
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	63	68	-5	107.9
620001	Удирдах ажилтан	12	12	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	30	35	-5	116.6
620003	Үйлчлэх ажилтан	19	19	0	100.0
620004	Гэрээт ажилтан	2	2	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	891,712,619.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	891,712,619.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	709,007,567.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	16,155,159.52
210105	Гэрээт ажлын хөлс	16,155,159.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,100,021.76
210201	Тэтгэврийн даатгал	2,100,021.76
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,799,654.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,799,654.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	600,952,732.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	594,536,732.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,416,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	182,705,051.72
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	182,705,051.72
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	182,705,051.72
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	891,712,619.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	891,712,619.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	414,082,847.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	477,629,772.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд балансын данстай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Алтантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/139 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Аймгийн ЗДТГ нь Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах чиг үүрэг бүхий аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Тус байгууллага нь тайлант онд *“Аймгийн засаг даргыг оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлнэ”* гэсэн зорилго тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас шилэн дансны хуулийн хэрэгжилтэнд хяналт хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 3,224.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 32.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 24.2 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус байгууллагын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн эхний үлдэгдлээс 359.9 сая төгрөгөөр буюу 10.8 хувиар өсч материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	Хувь
Б	1	2	3=2-1	
Бараа материал	43.0	45.2	2.2	5.1
Үндсэн хөрөнгө	3,289.1	3,646.8	357.7	10.9
Нийт хөрөнгө	3,332.1	3,692.0	359.9	10.8
Өр төлбөр	-	-		
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,332.1	3,692.0	359.9	10.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,332.1	3,692.0	359.9	10.8

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 5.1 хувиар өссөн байна.

Бараа материалын данс нь 43.0 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 176.0 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 4.0 сая нийт 179.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд зарцуулсан 177.8 сая төгрөгөөр хасагдаж, эцсийн үлдэгдэл 45.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 10.9 хувиар өссөн байна.

Үндсэн хөрөнгө данс нь 3,289.1 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй ба тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 34.4 сая, үнэ төлбөргүй хүлээн авсан 496.3 сая, шилжүүлэн авсан 4.9 сая төгрөг нийт 535.5 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацаанд байгуулсан 177.8 сая төгрөгийн элэгдлийн дүнгээр буурч, 3,646.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

- Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь тайлант хугацааны үр дүнг 359.9 сая төгрөгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт сая төгрөгөөр

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,880.6	3,212.3	1,331.7
Нэмэлт санхүүжилтийн орлого	2,372.4	891.7	(1,480.7)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	79.9	501.4	421.5
Төсөвт байгууллагын өөрийн орлого	27.4	20.8	(6.6)
Үйл ажиллагааны орлого	4,360.3	4,626.2	265.9
Цалин, шимтгэлийн зардал	948.3	1,081.0	132.7
Бусад бараа үйлчилгээний зардал	481.9	425.7	(56.2)
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	198.8	274.6	75.8
Бараа үйлчилгээний бусад зардал	2,661.5	1,782.7	(878.8)
Урсгал шилжүүлэг	163.3	702.3	539.0
Үйл ажиллагааны зардал	4,453.8	4,266.3	(187.5)
Үйл ажиллагааны бус зардал	11.2	-	(11.2)
Үйл ажиллагааны үр дүн	(104.7)	359.9	464.6

Санхүүгийн үр дүнгийн тайлангаарх урсгал үйл ажиллагааны санхүүжилт өмнөх оноос 1,331.7 сая төгрөгөөр буюу 70.8 хувиар өссөн нь ковид цар тахалтай холбоотойгоор аймгийн засаг даргын нөөц санг нэмэгдүүлэн баталж, зарцуулсантай холбоотой байна. Урсгал санхүүжилтээс 478.8 сая төгрөг хэмнэгдэж, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 1,856.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг анх 121.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,977.9 сая төгрөгөөр хянаж баталжээ. Мөн төсвийн тодотголоор 1,246.4 сая төгрөгөөр дахин нэмэгдүүлж, 3,224.3 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 3,224.3 сая төгрөгийн төсөв батлагдсан. Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 3,212.3 сая төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын өөрийн орлогоор 20.8 сая төгрөг төвлөрүүлэн нийт 3,233.1 сая төгрөгийн орлого, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 2,745.5 сая төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 487.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төвлөрүүлэх шилжүүлэг нь төсөвт байгууллагын өөрийн орлого 8.8 сая төгрөгөөр давж, бараа үйлчилгээний урсгал зардлууд болон засаг даргын нөөц хөрөнгө 478.8 сая төгрөг хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДТГ нь нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 891.7 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна. Үүнд:

- Архивын ерөнхийн газраас архивын гэрээт ажилчдын цалинд 18.3 сая төгрөг
- БХЯ-аас сургалтын зардалд 0.6 сая төгрөг
- БОАЖЯ-ны орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооноос гэр хорооллын айлуудын нүхэн жорлонг халдваргүйжүүлэх ажилд 80.0 сая төгрөг, Хог хаягдлыг бууруулах зардалд 10.0 сая төгрөг
- ЗГ-ын 240 дүгээр тогтоолоор Ковидын зардалд 24.6 сая төгрөг
- ЗГ-ын 138 дугаар тогтоолоор аймгийн аюулгүйн нөөц бүрдүүлэх зардалд 100.0 сая төгрөг
- ТАЗ-өөс ерөнхий шалгалтын зардалд 6.4 сая төгрөг
- ХХААХҮЯ, аймгийн Засаг дарга болон зах зээл ба бэлчээрийн удирдлагыг хэрэгжүүлэх нэмэлт санхүүжилтийн төслийн 683.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хамтарсан гэрээний 70 хувь буюу 478.1 сая төгрөгийг Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн зээлийн хөрөнгөнөөс, 30 хувь буюу 204.9 сая төгрөгийг аймаг, сумдын ОНХС-аас санхүүжилүүлэхээр гэрээ байгуулсны үндсэн дээр тус төслөөс 204.9 сая төгрөг, аймаг болон сумдын орон нутгийн хөгжлийн сангаас 176.1 сая төгрөг
- Аймгийн засаг даргын нөөц сангаас 33.0 сая төгрөг
- Нэмэлт санхүүжилтийн өмнөх оны татан төвлөрүүлэлт 102.0 төгрөг /2020 оны үлдэгдэл /
- Аймгийн засаг даргын гамшгийн зардлаас тусгаалах байрны зардалд 31.4 төгрөг,
- Барьцаа хөрөнгийн данснаас 89.2 сая төгрөг /2020 оны үлдэгдэл /
- Сангийн Яамнаас орон нутагт шинээр байгуулагдсан соёл урлагийн нэгжид шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах зардалд 15.0 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

Дээрх санхүүжилтээс цалингийн зардалд 16.2 сая төгрөг, НДШ-ийн зардалд 2.1 сая төгрөг, БГАҮТХ-ийн зардалд 89.8 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 600.9 сая

төгрөгийг тус тус зарцуулж, нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд 182.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна./ БОАЖЯ-ны 80.0 сая төгрөг, ОБГ-ын 63.2 сая төгрөг, соёл урлагийн нэгжийн тоног төхөөрөмжийн зардал 15.0 сая төгрөг, бусад хэмнэлт 24.5 сая төгрөгийг тус тус нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлт дансанд, БОАЖГ-ын тусгай зориулалттай автомашин худалдан авах 79.8 сая төгрөгийн анхан шатны баримтын бүрдэлгүй учраас гүйлгээ хийгдээгүй аймгийн барьцаа хөрөнгийн дансанд татан төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Дашзэвэ нь аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 5-ны Б/40 тоот захирамжаар ажлаас чөлөөлөгдөж, аймгийн засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 6-ны Б/41 тоот захирамжаар Ц.Бадрах ЗДТГ-ын даргаар томилогдон ажиллаж байна.

Тайлант онд ковид цар тахалтай холбоотойгоор төсвийн тодотголоор аймгийн засаг даргын нөөц санг 902.3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 1,384.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,003.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтыг Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын дагуу авч үзвэл: Нийт зарцуулалтын 35.5 хувийг журмын 2.1.1 дэх заалтын хүрээнд ковид цар тахал болон өвөлжилтийн бэлтгэлд, 31.3 хувийг 2.1.4 дэх заалтын хүрээнд иргэд байгууллагаас тавьсан хүсэлтийг шийдвэрлэхэд, 19.4 хувийг 2.1.5 дахь заалтын хүрээнд засаг дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой нэг удаагийн шинжтэй арга хэмжээнд, 13.8 хувийг 2.1.6 дахь заалтын хүрээнд шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгт тус тус зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 9 үндсэн зорилтын хүрээнд 157 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ХШҮДАХ-ээс 80.2 хувь гэж үнэлсэн байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 3,224.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 2,745.5 сая төгрөгийг зарцуулж, 85.2 хувийн биелэлттэй байна.

Тус байгууллага нь тайлант онд төсөвт байгууллагын өөрийн орлогоор 12.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 20.8 сая төгрөгийг төвлөрүүлэн орлогын төлөвлөгөөг 173.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаарх судалгааг авч үзэхэд
 - Батлагдсан төсөвт зардлаас 478.8 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.
 - Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.1 сая төгрөгөөр хэмнэж, бичиг хэргийн зардлыг төлөвлөсөн хэмжээнд зарцуулсан байна.

2. Тэргүүн болон эрхэлсэн түшмэлийн ангилал зэрэглэлд хамараах албан тушаалтны ажлын байрны нөхцлийн судалгаа: Эрхэлсэн түшмэл буюу аймгийн ЗДТГ-ын дарга нь 30 м² ажлын өрөөтэй, өөр бусад өрөө тасалгаагүй байна.
3. Суудлын автомашин ашиглалтын судалгаа: Тус байгууллага нь нийт 455.8 сая төгрөгийн анхны өртөг бүхий 6 автомашинтай, шатахуун, сэлбэг хэрэгслийн зардалд 49.1 сая төгрөгийг зарцуулсан, орон тооны 5 жолоочтой, жолооч нарын цалинд 45.2 сая төгрөгийг олгожээ.
4. Хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулан ажилласны төлбөрт 22.5 сая төгрөгийг олгосон байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аймгийн ЗДТГ нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 170 мэдээллээс 168 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хуулинд заасан хугацаанд тогтмол мэдээлж хэвших зөвлөмжийг хүргүүллээ.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

- Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын дагуу төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар авч үзэхэд 487.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгож, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.
- Тус байгууллага нь тайлант жил Сангийн Яамнаас хянасан орон тооноос 5 орон тоогоор илүү ажилласан бөгөөд харин аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар 04-ний өдрийн “Аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/517 тоот захирамж, аймгийн ЗДТГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Аймгийн ЗДТГ-ын нийтлэг үйлчилгээний газрын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” А/80 тоот тушаалаар батлагдсан орон тооноос 1 орон тоо буюу засаг даргын зөвлөхийн орон тоогоор илүү ажиллаж, цалинд 18.2 сая төгрөгийг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.3 “Батлагдсан

цалингийн сан, орон тооны хязгаарт багтан төсвийн байгууллагын ажиллагчдын орон тоо, цалин хөлсийг тогтоох”, Монгол Улсын ЗГ-ын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоолын “Орон нутгийн онцлог, нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, эдийн засаг, үйлдвэрлэлийн цар хүрээнээс хамааруулан Архангай,... аймгийн ЗДТГ-ыг 41 хүртэл орон тоотой байхаар тогтоосугай”, Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар 1.2-т “Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, ... цалингийн зардлыг хэмнэх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хууль, ЗГ-ын 377 болон 43-р тогтоолыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүлэх

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, мөн бусад хууль тогтоомжийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилт холбогдох шалгуурт бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдээгүй, төсвийн тодотголоор хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлыг 10.0 сая төгрөгөөр тооцоо судалгаагүйгээр нэмэгдүүлэн бүртгэлийн ажилтнуудын сургалтын зардалд зарцуулсан, төрийн жинхэнэ албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр 2 ажилтныг томилсон, шилэн дансанд 34 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан зэрэг 5 заалт бүхий зөвлөмж хүргүүлснийг 85 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол Улсын ЗГ-ын 2016 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай” 9 дүгээр тогтоол хүчингүй болж, Монгол Улсын ЗГ-ын 2021 оны “Аймгийн засаг даргын тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол батлагдсан тул дараагийн аудитаар ЗДТГ-ын бүтэц, орон тоог нарийвчлан авч үзнэ.

4. Аудитын илрүүлэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 113.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 33.0 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэн, 80.2 сая төгрөгийн зөрчилд хууь тогтоомжийг хэрэгжүүлэн холбогдох арга хэмжээг авч ажиллах зөвлөмж өглөө.

4.1 Албан шаардлага

Засаг даргын нөөц сангаас аймгийн засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 10-ны А/832 тоот захирамжаар Хотонт суманд өвс тэжээлийн агуулах, саравч барих зардалд 33.0 сая төгрөг олгосон нь Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 3.1.2-т “..., энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал тусгахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх арга хэмжээг авч, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан засаг даргын нөөц

хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг мөрдөж ажиллах албан шаардлагыг хүргүүллээ.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг хянаж үзэхэд элэгдлээ бүрэн нөхсөн, ашиглалтын хугацаа дууссан 37 нэр төрлийн 10.2 сая төгрөгийн тавилга эд хогшил, 14 нэр төрлийн 39.4 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2 нэр төрлийн 30.6 сая төгрөгийн программ хангаж нийт 80.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь ТБОНӨТХуулийн 31.1-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан ... эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн дээрх хөрөнгийг Өмч хамгаалах байнгын зөвлөлөөрөө хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулж, одоо ашиглаж байгаа болон цаашид ашиглагдах хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэх, ашиглалтын хугацаа дууссан, ашиглагдах боломжгүй болсон хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасны дагуу холбогдох арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн Аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Аймгийн ЗДТГ	2	113.2	0	0	0	0	1	33.0	1	80.2
	Дүн	2	113.2	0	0	0	0	1	33.0	1	80.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
2	Аймгийн ЗДТГ	2	18.2	0	0	0	0	1	18.2	1	0
	Дүн	2	18.2	0	0	0	0	1	18.2	1	0
	Нийт дүн	4	131.4	0	0	0	0	2	51.2	2	80.2